



НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 05 өдөр

Дугаар Д/33

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.11, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1368 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Нэмэлт гэрээ байгуулах тухай” А/1368 дугаар захирамжийн хавсралтаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын салбарт он дамжин хэрэгжиж байгаа Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд тусгагдсан, Үндэсний аудитын газрын дүгнэлт, зөвлөмж гарч, баталгаажсан, төсөвт өртөг нэмэгдэн батлагдсан төсөл, арга хэмжээний нэмэлт гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталгаажуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1368 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж нэмэлт гэрээг 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн дотор байгуулж, үр дүнг танилцуулахыг Ажлын хэсгийн дарга (Т.Оргил-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.


3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, дотоод хяналтын хэлтэс (Б.Батбилэг)-г даалгасугай.

ДАРГА



Б.МӨНХБАТ

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2023 оны 12 дугаар сарын 05-ны
өдрийн 1/33 дүгээр тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА

Т.ОРГИЛ-ЭРДЭНЭ
(Ерөнхий инженер)

ГИШҮҮД:

С.БААСАНСҮРЭН
(Барилга захиалагчийн
хэлтсийн зүүн бүсийн
Ахлах инженер)

Н.ЭНХБАЯР
(Барилга захиалагчийн
хэлтсийн баруун бүсийн
Ахлах инженер)

Н.НАРАНГЭРЭЛ
(Хууль, дотоод хяналтын
хэлтсийн Ахлах инженер)

Х.НАРАНЦЭЦЭГ
(Барилга захиалагчийн
хэлтсийн Дулаан хангамж,
агаар сэлтгэлтийн
хяналтын инженер)

Ж.СОЛОНГО
(Санхүү, аж ахуйн хэлтсийн
Хөрөнгө оруулалтын
санхүүжилт
хариуцсан мэргэжилтэн)

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.БАТЦЭНГЭЛ
(Зураг төслийн хэлтсийн
Зураг төслийн хяналтын
инженер)